

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2019 оны 10 дугаар сараас эхлэн аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дахин хуралдаж эхэлсэн ба энэ сард нийт 4 удаа хуралдав. Уг хуралдаанаар аймгийн удирдлагууд тус аймагт долоо хоногт болж өнгөрсөн үйл ажиллагаануудын талаар танилцуулж, хэлтэс, агентлагийн удирдлагуудын хэрэгжүүлсэн ажил, санал, хүсэлтийг сонсож, цаг үеийн асуудлаар нийт 27 үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллав.

Энэ сард Төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон Цэнгэл сум болон Буянт сумдын иргэдийн материалыг хүлээн авч танилцан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмын дагуу баримт бичгийг хянан шалгаж, материалыг холбогдох дээд газар, яаманд уламжлан ажилласан.

Мөн Ахмадын баяр, Багш нарын баяр болон аймгийн Хөгжимт драмын Казах үндэстний оркестр байгуулагдсаны 60 жилийн ойн баярын арга хэмжээнүүдийг тохиолдуулан аймгийн шагналаар шагнуулахаар аймгийн төв болон сум, орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн хүмүүсийн материалыг хүлээн авч танилцан, шагналын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох журмын дагуу аймгийн удирдлагуудад танилцуулан шийдвэр гаргуулж шагнуулсан. Үүнд шагналын болзлыг хангасан иргэдийг аймгийн “Хүндэт тэмдэг”, “Тэргүүний ажилтан”, Засаг даргын “Жуух бичиг” зэрэг шагналуудаар шагнасан болно.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сумын шинэлэг санаачлагын “Аравт” төслийн хэрэгжилтийн байдал, иргэдийн оролцоог хэрхэн сайжруулсан туршлагыг газар дээр нь очиж судлах туршлага солилцох арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Баян-Овоо суманд зохион байгуулж, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газраас удирдан бүх сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулав.

2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Авлигатай тэмцэх газрын албаны дарга, ахлах комиссар Т.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг Баян-Өлгий аймагт “Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг”-ийг зохион байгуулж, орон нутгийн иргэдтэй “Олон нийтийн хяналт ба шударга ёс” сэдвийн дор уулзалт хийлээ.

Өдөрлөгийн үеэр ажлын хэсгийн гишүүд иргэд, олон нийтэд Авлигатай тэмцэх газрын хуулиар хүлээсэн чиг үүрэг болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл хийж, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, олон нийтийн хяналт, шударга ёсыг тогтоох чиглэлээр иргэдийн санал бодлыг сонсож, зөвлөгөө өгч ажиллав.

Баян-Өлгий аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч болон Засаг даргын тамгын газрын дарга нар Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16.2, 16.3 дахь хэсэгт заасны дагуу 2019 оны аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн

чиглэлийн төслийг боловсруулан 10 дугаар сарын 4-ний өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад өргөн барив.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Хууль хяналтын үйл ажиллагаа

2.1.1. Хууль, эрх зүйн хэлтсийн мэдээлэл

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн Засаг даргын 95 ширхэг А захирамж, 3 ширхэг Б захирамжийг тус тус хянаж, Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн лавлах санд хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, эрх зүйн хэм хэмжээний актыг шинээр бүртгээгүй ба иргэдээс амаар болон бичгээр гаргасан хүсэлт, өргөдлийг хүлээж авч, 5 хүнд зөвлөгөө өгч үйлчлэв.

Мөн Сogтууруулах ундаа худалдах нөхцөл, шаардлагыг хангаж, улсын тэмдэгтийн хураамж төлсөн 3 дэлгүүрт спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар сунгаж зөвшөөрөл олгов.

2.2. Шүүхийн шинжилгээний албаны мэдээлэл

№	Тайлбар	Тухайн сар	Оссон дүн
1.	Криминалистикийн шинжилгээний тоо	2	61
2.	Хэргийн газрын үзлэгт оролцсон тоо	26	273
3.	Гутлын мөр	5	44
4.	Тээврийн хэрэгслийн мөр	2	52
5.	Эвдлэгч багажийн мөр	0	7
6.	Биологийн гаралтай ул мөр	2	11
7.	Бусад ул мөр	8	149
8.	Хонгио хошуу	-	69
9.	Гарын дардас	20	119
10.	Гарын мөр	5	31
11.	Шүүх эмнэлгийн хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо	40	425
12.	Шүүх эмнэлгийн бэлгийн холбогдолтой шинжилгээний тоо	4	12
13.	Цогцост хийсэн шинжилгээний тоо	7	40
14.	Тусгай шинжилгээ болон химийн шинжилгээний тоо	15	99

2.3. Улсын бүртгэлийн хэлтэс

№	Заалт	Биелэлт
1.	Иргэдийн баримт бичгийн зөрчлийн арилгат хувь	99,9
2.	Шилжих хөдөлгөөн /шилжиж ирсэн/ хот доторх	91
4.	Гадаад паспорт эзэмшигчдийн тоо	289
5.	Шинээр гэрлэлт /тоо/	92

2.4. Онцгой байдлын газрын мэдээлэл**Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын нэгдсэн мэдээ**

№	Тохиолдсон аюулт үзэгдэл, осол	Тохиолдсон тоо	Хамарсан		Нас барсан хүн	Шатсан талбай ой, хээр /га газар/	Ажилласан		Зардал /мян.төг/	
			Аймаг, нийслэл	Сум, дүүрэг			Хүн	Техник		
1	Гал түймэр	Ой, хээрийн түймэр	1	1	1	-	1,5	15	2	131,4
		Объектын түймэр	5	1	1	-	-	18	3	109,5
		Бусад Техникийн холбогдолтой осол	1	1	1	1	-	6	1	28,2
2	Хүчтэй салхи	1	1	1	-	-	-	-	10,0	
Бүгд		8	4	4	1	1,5	39	6	279,1	

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3. Эрүүл мэндийн чиглэлээр

2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Эмгэг судлалын үндэсний төв Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, сувилагч нарыг чадавхжуулах” нь сургалтыг зохион байгуулж харьяа эрүүл мэндийн байгууллагын эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, сувилагч зэрэг 40 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан.

Аймгийн Цагдаагийн газар, Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газар, Ногооннуур сумын Сум дундын эмнэлэгтэй хамтран Ногооннуур сумын эмзэг бүлгийн 5 иргэнийг сүрьеэ, ДОХ, тэмбүү илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, зөвлөгөө өгч ажилласан. Өвчлөл илрээгүй болно.

Ховд Их сургуулийн тус аймаг дахь салбар сургуулийн 140 оюутанд Сүрьеэ, БЗДХ, ДОХ, А гепатит, Томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай сургалтыг явуулсан.

“Тэмбүүг устгая” аяны хүрээнд 10-р сарын 4-17-ны хооронд тэмбүү илрүүлэх шинжилгээнд 510 хүн хамрагдсанаас шинээр 3 тэмбүү илрүүлж, эмчилгээнд хамруулж байна.

“Оюунлаг алхам” цэцэрлэгийн нийт 10 багш, ажилчид болон Өлгий сумын Дарын цогцолбор сургуулийн 6-12 дугаар ангийн 331 сурагчдад “А гепатит өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Гарын эрүүл ахуй, гар угаах дараалал”, “Угаарын хийн хордлогоос сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, “Жавелион бодис хэрэглэх заавар, ариутгал, халдваргүйтгэл”, ЭМС-ын 216 тоот тушаалыг тус тус танилцуулсан.

Намрын бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд аймгийн Эрүүл мэндийн газрын хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, байгууллагын хашаа, ойр орчмын хогийг цэвэрлэж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон.

Монгол улс Нэгдсэн Үндэсний байгууллагад гишүүнээр элссэний 58 жилийн ойг угтан “Эрүүл мэндийнхээ төлөө-Алхангаа ярилцъя” уриан дор Дэлхийн алхалтын өдрийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир, спортын газар, Цагдаагийн газар хамтран зохион явуулсан ба нийт төрийн болон төрийн бус байгууллагуудын 258 хүн оролцсон.

10 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанаас 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын баг ирж аймгийн ЭМГ, сүрьеэгийн тасаг, диспансерт дэмжлэгт хяналт-үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

Аймгийн Засаг даргын 2019 оны “Бүх нийтээр мод тарих сарын ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” А/332 дугаар захирамжийн дагуу НААҮ-ний “СУАТ” ХХК-ийн Цэвэр усны байгууламжийн хашааны дотор Эрүүл мэндийн газрын хамт олон бүх нийтээрээ мод тарьж ажилласан.

2019 оны 3 дугаар улиралд аймгийн хэмжээнд гарсан нярайн эндэгдлийн тохиолдлын шалтгааныг магадлан хэлэлцэх хурлыг зохион явуулж, хуралд магадлан хэлэлцэх зөвлөл, аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн холбогдох дарга, эмч, эх баригч нарын 30 гаруй эмч мэргэжилтнүүд оролцсон. Энэ удаагийн хуралд хэлэлцсэн нярайн эндэгдлийн 10 тохиолдлын 6 тохиолдолд буюу 60%-д эмгэг судлалын шинжилгээ хийгдсэн нь эмч нарын тавьсан оношийн баталгаажилтад үр дүнгээ өгсөн.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/666 захирамж, “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 9 дүгээр сарын 30-ны өдөр Спортын цогцолборт Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, 4 өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн Ахмадын хороотой хамтран ахмад настанд цусны даралт үзэх, сахар үзэх, биеийн жингийн индекс болон биеийн найрлагыг тодорхойлох ажлыг зохион байгуулж, 39 эмч, мэргэжилтнүүд нийтдээ 259 ахмадыг ЭХО үзлэгт хамруулсан.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байранд А гепатит өвчний 1 тохиолдол бүртгэгдэж, голомтод тандалт судалгаа, ариутгал халдваргүйтгэл хийж, 8 үйлчилгээний ажилтнуудад гарын эрүүл ахуй, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл, А гепатит өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт хийж, МСҮТ-ийн дотуур байрны 93 хүүхдийг А гепатит өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан сургуулийн гал тогоо, анги, танхим, ариун цэврийн байгууламжид хяналт-үнэлгээ хийж, илэрсэн алдаа, зөрчлийг анхааруулж зөвлөмж хүргүүлсэн.

Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 10 дугаар сарын 4-нээс 17-ны өдрүүдэд “Томуугаас сэргийлье” уриан дор эмч, эмнэлгийн ажилчид болон эрсдэлт бүлгийн жирэмсэн эх, архаг хууч өвчтэй, 65-аас дээш насны хүмүүсийн дунд зохион явуулж томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулав.

Сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан 6 сартайгаас 5 хүртэлх насны хүүхдүүдэд өндөр тунт А аминдэмийг тарааж байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛ ДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4. Дэд бүтцийн чиглэлээр

4.1. Цахилгаан хангамжийн талаар

Аймгийн хэмжээнд Баруун бүсийн эрчим хүчний системээс 38130.0 мян.кВ.цаг цахилгааныг худалдан авч, 31715.0 мян.кВ.цаг цахилгаан худалдан борлуулсан. Нийт 6415.0 мян.кВ.цаг цахилгааныг шугамд алдсан. Нийт алдагдал 16.8%-тай байгаа. Худалдан борлуулсан цахилгаанд 4241.0 сая төгрөгийн нэхэмжлэл бичиж, 4487.0 сая төгрөгийг цуглуулсан. Борлуулалтын орлого 106%-ийн цуглуулгатай байна.

4.2. Холбооны талаар

Тус газар нь 2019 оны 10-р сард шуудангаар болон мэйл хаягаар компаниас 3, орон нутгийн бусад байгууллагаас 5, нийт 8 албан бичгийг хүлээн авч тухай бүр бүртгэл хөтлөн, байгууллагын удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтнуудад шилжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Мөн газрын үйл ажиллагааны асуудлуудаар албан байгууллагад 6 албан бичиг боловсруулан хүргүүлж хариу, шийдвэр гаргуулж ажиллав.

4.3. Аймгийн радио телевизийн сүлжээний ажлын талаар

Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн бүх сумуудын тоон телевизийн станцуудыг МонСат системд шилжүүлэв.

10 дугаар сарын 17-ны өдөр 08:00-12:00 цагийн хооронд радио нэвтрүүлэгчдэд, 10:00-12:00 цагийн хооронд тоон телевизийн тоног төхөөрөмжүүдэд энэ сарын ээлжит үзлэг үйлчилгээг хийв.

4.4. Усны талаар

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд цэвэрлэх байгууламжийн 2 дахь биоцөөрмийн картын 510м³ лагийг цэвэрлэж, лаг хатаах талбайд буулган цэвэрлэх байгууламжийн бохир ус хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэн ажилласан.

Аймгийн төвийн цэвэр, бохир усны худгуудын усны алдагдлыг нэг бүрчлэн шалгаж, усны алдагдлыг таслан зогсоох арга хэмжээ авав.

Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны хүсэлтийн дагуу тус байгууллагыг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбож, дотор талын монтажыг хийж гүйцэтгэв.

Бохир усны гол магистрал шугамуудад гарсан бөглөөсийг цаг тухайд нь арилгаж, хэвийн ажиллагаанд оруулсан.

“СУАТ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал болж, компанийн 2019 оны 9-р сараас хойш хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн болон цаашид хийж хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, зохих шийдвэрүүдийг гаргав.

Нийтийн аж ахуйн байгууллага үүсч хөгжсөний 88 жилийн ойг тохиолдуулан тус компаниас зохион байгуулж буй “Азтан шалгаруулах” болзолт уралдааны хүрээнд нийт 1800 хэрэглэгчдэд 2500 ширхэг сугалааны эрх олгогдсон ба уг болзолт уралдааныг 2019 оны 11-р сард компанийн байранд зохион явуулахаар төлөвлөж байна.

4.5. Авто тээврийн талаар

Хот хоорондын чиглэлд “Газрын Од” ХХК-ийн том оврын 24 АЕРО автобус, “Цэнгэлтранс” ХХК-ийн том оврын 15 АЕРО автобус, нийт 39 тээврийн хэрэгслээр хот хоорондын байнгын үйлчилгээнд зорчигч тээвэрлэж байна.

Улс хоорондын Өлгий-Алмата хотын чиглэлд орчин үеийн АЕРО, ЮТИОНГ том оврын автобуснуудаар зорчигч тээвэрлэх, шинээр рейс нээх ажлууд явагдаж байна.

Улс хооронд болон хот хоорондын зорчигч тээврийн мэдээг өдөр бүр Автотээврийн үндэсний төвийн 70070012 утсанд цаг тухайд нь өгч ажиллав.

Энэ сард улс хооронд нийт 8 рейсээр 344 зорчигч, хот хооронд 57 рейсээр 2565 зорчигчийг тээвэрлэж аюул осолгүй, чирэгдэлгүй ард иргэдэд тавь тухтай үйлчилгээ үзүүлэв.

4.6. Нисэх буудлын үйл ажиллагааны талаар

2019 оны 10 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 31-нийг хүртэл нийт 4 агаарын хөлөг хүлээж авснаас “Хүннү-Эйр” ХХК-ийн 20 рейсийн агаарын хөлөгөнд 632 том хүн, хагас зардал 16 амь даатгал 27, ачаа 820 ш, гар тээш 432 ш, 33ш шуудан “Аэро-Монголиа” ХХК-ийн 18 рейсийн агаарын хөлөгөнд 688 том хүн, хагас зардал 23, амь даатгал 40, ачаа 913 ш, гар тээш 771 ш, 3 ш шуудан, “Геосан” ХХК-ийн 2 рейсийн агаарын хөлөгөнд 5 том хүн, ачаа 8 ш, гар тээш 5 ш, “Тэнгэрийн улаач” ХХК-ийн 1 рейсийн агаарын хөлөгөнд 5 том хүн, ачаа 4 ш, гар тээш 5 ш, нийт 41 рейс, 1416 нийт зорчигч, 1745 ш нийт ачаа, Нисэх буудлын ажилчдыг давхардсан тоогоор 612 удаа, ажилчдын гар тээш 25 ширхгийг аюулгүй байдлын үзлэгт хамруулав. Нэг удаагийн үнэмлэхийг 6 хүнд өгөв.

Өдөрт 2 нислэгтэй ямар нэгэн зөрчилгүй нислэгийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллав.

Бүх тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ хийж ямар нэгэн сааталгүй ажилласан болно.

10-р сарын нислэгийн тоо:

№	Авиа компани	Агаарын хөлгийн маяг	Нислэгийн тоо
1	Аэро-Монголиа	ER 145	18
2	Хүннүү-Эйр	ATR-72 / ERJ160	20
3	Геосан	AA510	2
4	Тэнгэрийн улаач	JU9999/	1
Нийт			41

ТАВ. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

1. БУЛГАН СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

10 дугаар сард намрын ээлжит цэрэг татлагын ажил явагдаж, цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүл мэндийн үзүүлэлтээр тэнцсэн 11 залууг цэргийн хугацаат албанд явуулав.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд сумын ЗДТГ-ын дарга Хэнтий аймгийн Баян-Овоо суманд ажиллан туршлага судалж сумын “Аравтын” системийн үйл ажиллагаатай танилцсан ба уг системийг өөрийн суманд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Аймгийн Онцгой байдлын газартай сумын Засаг даргын Тамгын газрын даргын хийсэн гэрээний дагуу Онцгой байдлын команд штабын сургуулийг тус суманд зохион явуулж уг арга хэмжээнд аймгийн Онцгой байдлын газрын дэд дарга, сургалт хариуцсан мэргэжилтэн нар оролцож команд штабын сургуулийг удирдав. Энэхүү сургалтад сумын Онцгой комиссын мэргэжлийн ангиуд болон төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нар оролцож, 2 өдөр явагдсан сургалтад “хангалттай” дүн үзүүлэв.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Энэ сард сумын төсөвт байгууллагуудын санхүүжилт гүйцэд ирсэн боловч сарын санхүүгийн тайлан эцэслэн гараагүй байна.

Гурав. Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд

Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут сумдын Засаг дарга нартай мал оторлуулан өвөлжүүлэх гэрээ хийж, гэрээнийхээ дагуу ихэнх малчид малаа оторлуулан өвөлжүүлж эхлээд байна. Сумын орон нутгийн нөөцөд 600 ширхэг пресс өвс бэлтгэсэн.

Дөрөв. Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүч, дэд бүтцийн бодлогын хүрээнд

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх дэд бүтцийн ажлууд хэвийн явагдаж байна. Үүнд: Сөнхөл багт автомашин, мотоциклийн гүүр баригдсан бол Улаанхус багт мото гүүр баригдсан. Мөн аймгийн хөрөнгө оруулалтаар Улаагчины замын засварын ажил 140 сая төгрөгийн төсөвтэй хийгдэж, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 200 сая төгрөгийн өртөгтэй сумын төвийн хатуу хучилттай авто зам ашиглалтад тус тус өгөгдсөн.

Тав. Эрүүл мэнд, спортын талаар

Сумын 3 сургууль, 2 хүүхдийн цэцэрлэгийн ажил хэвийн явагдаж байна. Сумын ерөнхий боловсролын сургуулиуд 10 дугаар сарын 25-наас эхлэн нэгдүгээр улирлын амралтаа авч сургуулийн багш сурагчид амарч байгаа болно.

Зургаа. Боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар

Тус сумын эрүүл мэндийн төвд 10-р сард 7 эх амаржиж, 7 хүүхэд эсэн мэнд бойжиж байна. 7 эхийн төрөхийн ор хоног 35 ор хоног байгаа ба хяналтад 77 эх байна. Нас баралт 2 гарснаас 1 нь эмэгтэй 1 нь эрэгтэй хоёулаа гэрт нас барсан. Хүүхдийн эндэгдэл гараагүй. Эрүүл мэндийн төвд нийт 52 хүн хэвтэн эмчлүүлсний ор хоног 355 ор хоног байна. Халдварт бус өвчлөл 38 бүртгэгдэж, түргэн тусламжийн дуудлага 75 гарснаас 50 нь алсын дуудлага байв. Үзлэгийн тоо бүгд 670 байснаас урьдчилан сэргийлэх үзлэг 180, амбулаторын үзлэг 310 хүн тус тус хамрагдсан. Вакцинжуулалтад 355 хүүхэд хамрагдсан байна.

2. ТОЛБО СУМ

Нэг. Удирдлага зохион байгуулалт, хууль, эрх зүйн чиглэлээр

10 дугаар сарын 2-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газрын нийт ажилтан, албан хаагчид болон бүх байгууллагын дарга, эрхлэгчдийг цуглуулан хурал зохион байгуулж, уг хуралдаанаар “Хариуцлага дэг журмыг чангатгах” тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг авч хэлэлцэв. Тогтоолын хэрэгжилтийн явцыг дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв.

Зэвсэгт хүчний жанжин штабын даргын болон аймгийн Засаг даргын захирамжийн дагуу тус суманд ээлжит цэрэг татлагын ажлыг амжилттай зохион байгуулав. Цэрэг татлагад нийт 115 залуучууд хамрагдсанаас 16 цэрэг тэнцэж аймгийн Нэгдсэн эмнэлгийн үзлэгээр 7 цэрэг эрүүл мэндээрээ тэнцэв. Уг цэргүүдийн 3 нь ар гэрийн байдлаар чөлөөлөгдөж сумаас нийт 4 цэргийг цэргийн албанд явуулсан.

Мөн баримт бичгийн стандартыг хатуу мөрдөж, хэвлэмэл хуудаст тавих шаардлагыг хангаж, зориулалт эрх зүйн үндэслэлийг зөв гаргахыг холбогдох албан тушаалтанд анхааруулан ажиллаж байна. Тухайн сард 26 ирсэн бичгийг, 24 явуулсан бичгийг, өргөдөл 4, гомдол 1, санал 11, сумын Засаг даргаас гарсан 5 захирамжийг,

Засаг даргын зөвлөлийн 1 хурлын тэмдэглэлийг бүртгэлд авч бүртгэлийг зааврын дагуу хөтөлж шийдвэрлэлтийн явцад болон 14 хариутай бичгийг хяналтад авч хариуг хугацаанд явуулж ажиллав.

Хоёр. Боловсролын талаар

Сургуулийн сурагч, багш нараас түүврийн аргаар сорил авч мэдээллийн санд оруулав.

“Багшгүй нэг өдөр” үйл ажиллагааг 12-р ангийн сурагчид хариуцаж явуулан багш нарын дунд “Элсэн цаг” тэмцээн, мөн сургуулиас төрөн гарсан алдартнуудыг сурталчлах ажил явагдав.

“Ирвэсийн эх нутаг-2018” фестивалд сургуулийн төлөөллүүд оролцож аймагт тэргүүн байранд шалгарлаа.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр

10 дугаар сард 27 хүн хэвтэн эмчлүүлсэн ба амбулаторын үзлэгт 578 хүн, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 245 хүн хамрагдав. Эрт илрүүлгийн шинжилгээнд 150 хүн, умайн хүзүүний өмөн илрүүлэх эсийн шинжилгээнд 12 хүнийг тус тус хамааруулав.

Энэ сарын нийт төрөлт 3 байсан ба төрсөн эхийн гэрийн эргэлт 9, шинээр хяналтад 6 эх орсон. Одоо жирэмсний хяналтад 60 эх хянагдаж байгаа ба үүнээс эрсдэлтэй бүлгийн эхийн тоо 12.

Элэгний “В, С” вирус илрүүлэх шинжилгээнд 230 хүн хамаарагдсанаас 1 хүн “С” вирустай, 2 хүн “В” вирустай гарсан. Хүүхдийн дархлаажуулалтад 25 хүүхэд хамрагдсан. Цэцэрлэгийн 65 хүүхдэд “А” витамин уулгав.

Дөрөв. Байгаль орчны чиглэлээр

2019 онд үйлдвэрлэлийн болон тусгай зориулалтаар агнуулах ан амьтны захиалгыг хуулийн хугацаанд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт сумын Засаг даргын албан тоотоор хүргүүлэв.

Зам барилгын ажлыг гүйцэтгэж буй “Чайна Хуаши Энтерпрайзиз” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.

Тав. Улсын бүртгэлийн талаар:

№	Бүртгэлийн нэр	Өмнөх сард хийсэн нийт бүртгэл	Тухайн сард хийсэн бүртгэл	Нийт тоо
1	Төрсний бүртгэл	84	14	98
2	Үрчилсний бүртгэл	3	0	3
3	Овог, эцэг\эх\-н нэр, нэр өөрчилсний бүртгэл	1		
4	Гэрлэлтийн бүртгэл	19	5	24
5	Нас барсны бүртгэл	15		15
6	Иргэний үнэмлэх олголт	188	30	218
7	Шилжин явсны бүртгэл	68	11	79
8	Шилжин ирсний бүртгэл	36	7	43
9	Шинэчилсэн бүртгэл \хурууны хээ\	172	18	190
10	Иргэний үнэмлэх дахин олголт	13	1	14
11	Гэрлэлт цуцалсны бүртгэл			

3. САГСАЙ СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалт, хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Олон улсын Ахмадын өдрийн арга хэмжээг сумын Ахмадын хороо, төсвийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 300-аад ахмад настангуудыг оролцуулан хүндэтгэл үзүүлэн тус арга хэмжээнд 1.5 сая төгрөгийг зарцууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2019 оны 9/112 дугаар Цэргийн ээлжит татлага явуулах тухай албан бичгийн дагуу сумын Засаг даргын захирамжийг гаргуулан, бүх багийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгч, тус суманд цэрэг татлагын ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллав. Цэрэг татлагад 68 цэргийн насны эрчүүд хамрагдаж, цэргийн жинхэнэ албанд тэнцсэн 17 залуусыг аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулав. Цэргийн жинхэнэ албанд тэнцсэн 17 эрчүүдийг Цэргийн штабт хүлээлгэж өгснөөс 10 иргэн цэргийн жинхэнэ албанд татагдаж, 4 иргэн хилийн 0123 дугаар ангид, 6 иргэн 0130 дугаар ангид тус тус хуваарилагдлаа.

Хууль сурталчлах Мэдээллийн цагийг 10 дугаар сарын 1-нээс эхлүүлсэн ба одоогоор 1 удаа зохион явууллаа.

Аймгийн Онцгой байдлын газрын Галын аюулгүй байдлын хяналт-шалгалтад бүх төсөвт байгууллага хамрагдлаа.

Албадлагын арга хэмжээний хүрээнд хураан авсан 34.5 л /архи 15л 30ш, пиво 19.5 л 11ш/ согтууруулах ундааг орон тооны бус зөвлөлийн хуралдааны шийдвэрээр улсын орлого болголоо.

Төрийн албаны зөвлөлийн ерөнхий шалгалтын тов, бүртгэлийн талаар иргэдэд мэдээлэл өгч, бичиг баримт бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллав.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс суманд Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулан 200 иргэн оролцож, мэдээллээр хангагдсан ба сум иргэний бүртгэлийн бүх төрлийн лавлагааг гаргах онлайн сүлжээнд холбогдлоо.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын хэсэг сумын төв болон 6-р багийн төв /Даян/-д иргэдтэй уулзалт зохион байгуулж, 224 иргэн хамрагдаж, холбогдох хууль тогтоомжийн талаар, Төр засаг, аймаг орон нутгаас хийгдсэн ажил, бодлого, шийдвэрийн талаар мэдээллээр хангагдлаа.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос хүн, ам өрхийн мэдээллийн санд шинээр нэмэгдсэн 9 үзүүлэлтүүдийн баяжуулалт хийх, мэдээллийн санг сайжруулах талаарх өгөгдсөн үүргийн хүрээнд сумын хэмжээнд байгаа 1285 өрхийн 5222 иргэний мэдээллийг нэг бүрчлэн тодруулан, асууж лавлан, үнэн зөвөөр өрхийн бүртгэлийн дэвтэр нээв.

Сумын Засаг даргын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2018 оны төлөвлөгөөний биелэлт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн сумд холбогдолтой заалтуудын биелэлтийг нэгтгэн гаргаж байна.

Суманд байгаа галт зэвсгийн нэгдсэн тооллогыг явуулж байна.

Сумын иргэний бүртгэлд шинээр төрсөн 18, гэрлэсний 8, үрчилсний 2, иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 27, шилжин ирсэн 0, шилжин явсан 0, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн ҮХХ-ийн бүртгэлд 2, газар өмчлөх бүртгэлд 3, нас барсны бүртгэлд 2 иргэнийг тус тус бүртгэж, 30 иргэнд цахим үнэмлэх олгов.

Нотариатын үйлчилгээг 40 иргэнд үзүүлж, тэмдэгтийн хураамжид 48,400 төгрөг оруулав.

Иргэдээс ирсэн 23 төрлийн өргөдөл гомдлыг хүлээн авч, барагдуулах ажил зохион байгуулав. Ирсэн 27 бичгийг бүртгэж түүний мөрөөр ажил зохион байгуулж, 27 албан бичгийг холбогдох газруудад явуулав.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсөвт байгууллагуудад 10 дугаар сард ирсэн төсвийг холбогдох зардлын зүйл ангиудад хуваарилан зарцуулснаас 520,861,132 төгрөгийн 279 төрлийн гүйлгээ хийгдсэн. Мөн 4,301,622 төгрөгийн татварын орлогыг оруулсан.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын НДШ-ийн өр 54,845,893 төгрөг байна.

Гурав. Хөдөө аж ахуй, газар тариалан, байгаль орчны бодлогын хүрээнд

Сумын хэмжээнд ургац хураалтын эцсийн мэдээгээр нийт 260 тн төмс, 63.4 тн хүнсний ногоо, 11.5 тн чацаргана, 200 тн малын тэжээл, 4300 тн өвс, 300 тн гар тэжээл, 580 тн хужир давс хурааж авсан. Сумын аюулгүйн нөөцөд 60 тн өвс бэлтгэсэн. Мөн 314 иргэн 36510 кг ноосыг үндэсний үйлдвэрүүдэд тушаасан.

Улаан дэлийн услалтын системээс 100 ш чацарганын суулгац, аймгаас 50 ш бургасны суулгацыг худалдан авч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад намрын тариалалт хийлгэв.

Дөрөв. Боловсрол соёл, шинжлэх ухааны талаар

Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан ахмад багш, ажилчдад хүндэтгэл үзүүлэв.

Сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн “Намрын спартакиад”-ыг сурагчдын дунд зохион явуулав.

Сургуулийн номын сангаас “Номын 10 хоног”-ийн тусгай хөтөлбөр боловсруулан багш, сурагчдын дунд уран уншлага, яруу найраг, ханын сонин болон ангийн номын санг баяжуулах зэрэг олон төрлийн үр өгөөжтэй уралдаан, тэмцээнүүдийг зохион явуулж дүгнэв.

Сум хөгжүүлэх сангийн санхүүжилтээр сургуулийн биеийн тамирын зааланд 4.9 сая төгрөгийн өртөг бүхий засвар, тохижилтын ажил хийгдэж байна.

Дотуур байранд эцэг, эхийн эргэлтийн өрөө нээж, ашиглалтад оруулав.

Хүүхдийн цэцэрлэг 9 бүлэгт 265 хүүхдийг хамруулан ажиллаж байна.

Төрийн аудитын газраас 2016, 2017, 2018 оны цэцэрлэгийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаа, хүүхдийн хоолны хүрэлцээ, сургалт, зохион байгуулалтын ажлуудад хяналт-шалгалт хийж “хангалттай” дүгнэгдэв.

Тав. Эрүүл мэнд, спортын талаар

Тус сард 7 эх хөнгөрсөн ба эмнэлэгт 45 хүн 315 ор хоног хэвтэж эмчлүүлсэн. Вакцинжуулалтад 81 хүн хамрагдсан ба одоо 79 жирэмсэн эх хяналтад байна. Эх, хүүхдийн эндэгдэл гараагүй. Нийт 38 удаа түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлсэн.

Зургаа. Нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар

10 дугаар сарын Нийгмийн даатгалын сан, Хөдөлмөр халамжийн сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж хугацаандаа ирж Хаан банк, Төрийн банкаар дамжуулан олгогдож байна. Халамжийн сангийн санхүүжилт нь хүрэлцэхгүй явдал гарсаар байна.

Шинээр өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор ирүүлсэн 5 хүний өргөдлийг хүлээн авч барагдуулах ажлыг зохион байгуулсан.

Сумын аж ахуйн нэгж байгууллагууд эхний 10 сарын байдлаар Нийгмийн даатгалын шимтгэлийн 54,845,893 төгрөгийн өр, авлагатай байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдахаар төсөл ирүүлсэн 4 иргэнийг /үхрийн ферм 3, домбор 1/ 18,0 сая төгрөгийн бага хүүтэй зээлд хамруулав.

Нийгмийн халамжийн зайлшгүй шаардлагатай хүнсний эрхийн бичигт нийт 112 өрх хамрагдав.

Нийгмийн халамжийн тахир дутуугийн тэтгэврийг 118 иргэн, тэжээгч алдсаны тэтгэмжийг 25 иргэн, нярай болон жирэмсэн эхийн тэтгэмжийг 159 эх, бүтэн өнчин хүүхдийн тэтгэмжийг 12 иргэн, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны тэтгэмжийг 22 хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай 19–ээс дээш насны асаргааны тэтгэмжийг 11 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 40 ахмад настан тус тус авч байна.

Ажил идэвхтэй хайж буй 9 иргэнийг шинээр LMIS программд бүртгэв.

4. ЦАГААННУУР ТОСГОН

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Удирдах ажилтны шуурхай хуралдааныг 3 удаа хийж 7 хоногийн болон цаг үеийн асуудлыг хэлэлцүүлэн шийдвэр гарган ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/578 тоот “Өвөлжилтийн бэлтгэл хангуулах тухай” захирамжийн дагуу тосгоны байгууллагууд өвөлжилтийн бэлтгэлээ бүрэн базааж дулаалга хийж, түлээ нүүрс, хүнсээ бэлдсэн.

Авилгатай тэмцэх газраас аймгийн төвд зохион байгуулсан ХОМ-г бүтээх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын сургалтад хамрагдав.

Тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид болон сурагчдаас дотуур байрны өөрийн үнэлгээ авч нийлбэрийг гаргасан ба 57,22%-тай гарч жил болгон өсөж, сайжирч байгаа болно.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

1. Хилийн 0285-р анги /Үндсэн цалин/	-	236,827,600.00
2. Дунд сургууль /Үндсэн цалин/	-	27,741,100.00
3. Хүүхдийн цэцэрлэг /Үндсэн цалин/	-	16,378,696.00
4. Эрүүл мэндийн төв /Үндсэн цалин/	-	18,852,200.00
5. Соёлын төв /Үндсэн цалин/	-	4,200,500.00
6. Захирагчийн алба /Үндсэн цалин/	-	10,076,800.00
Бүгд		314,076,896.00

Гурав. Статистик мэдээний талаар

2020 оны хүн амын урьдчилсан тооллогын ажлыг зохион байгууллаа. Хүн амын тооллогын явцад шинээр нэмэгдсэн өрх, мэдээллийн санд ороогүй шинээр төрсөн

хүүхэд болон шилжиж ирсэн хүмүүс, явсан хүмүүс мөн байршил тодорхойгүй өрх , нас барсан хүн гэх мэт бүртгэлийн ажлуудыг бүрэн хийж дуусгав.

Цагааннуур тосгоны суурийн хүн амын тоо 1657, өрхийн тоо 430, эрэгтэй 813 буюу 49,06%, эмэгтэй 844 буюу 50,94% тус тус мэдээллийн санд бүртгэлтэй байгаа болно.

Дөрөв. Боловсрол, соёлын талаар

10-р сарын 5-ны өдөр Монголын багш нарын 53 дахь жилийн ойн баярыг тэмдэглэн баярын хурал хийж, идэвх зүтгэлтэй ажилласан багш, ажилчдын шагналыг гардуулж, баярын арга хэмжээ зохион байгуулав.

Дотуур байрны багш болон бүх анги удирдсан багш нар эцэг эхийн хурал хийж гурвалсан гэрээ байгуулсан.

Боловсрол, соёл, урлагийн газраас багш нарын баярыг тохиолдуулан зохион явуулсан багш нарын “Урлагийн анхдугаар их наадам”-д сургуулийн багш, ажилчид амжилттай оролцов.

Тав. Эрүүл мэндийн талаар

Статистик мэдээлэл:

Бүгд үзлэг	-	392
Үүнээс: Урьдчилан сэргийлэх үзлэг	-	89
Амбулаторийн үзлэг	-	109
Гэрийн дуудлагын тоо	-	38
Алсын дуудлага	-	17
Нас баралт	-	0
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн	-	12 хүн
Эмнэлгээс эмчлүүлж гарсан	-	11 хүн
Өдрийн эмчилгээнд хамрагдсан	-	14 хүн
Аймагт төрсөн эх	-	2
Өөрийн эмнэлэгт төрсөн	-	0
Аймагт шилжүүлсэн жирэмсэн эх	-	3
Хяналтад байгаа жирэмсэн эх	-	25
Үүнээс: Шинээр хяналтад авсан жирэмсэн эх	-	4
Дархлаажуулалтад хамрагдсан хүүхэд	-	23

Зургаа. Нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар

Энэ сард тосгоны захирагчийн А/46 тоот захирамжаар ахмадуудад хүндэтгэл үзүүлэв.

Нийгмийн халамж, үйлчилгээнээс авах хүмүүсийн тэтгэвэр тэтгэмжүүдийг олгох ажлыг зохион байгуулж “Цалинтай ээж” хөтөлбөрт 6 эхийг хамруулж, Тэжээгч алдсаны тэтгэвэрт 1, 0-18 насны хүүхэдтэй 3-4 хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжид 1 эх, жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эхийн нөхцөлт мөнгөн тэтгэмжид 5 эх тус тус нэмэгдэв.

